

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 01 сарын 08-ны өдөр

Дугаар

БА-005/2025

Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сонгинхайрхан дүүргийн 37 дугаар хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 21 (хорин нэг) автомашины дулаан зогсоолтой, 262 (хоёр зуун жаран хоёр) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2024 оны 12 сарын 16-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2023/03/27, 0012428 дугаар, БАЗГ2023/081;

2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: АП-01/20;

2.3. Захиалагч: Мөнхийн Эхлэлийн Гараа ХХК оноосон нэр, 000231141 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6868541 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, 5 хороолол, 39, 114 тоот, 76112999, 99113277 холбоо барих утас, [munkhiinekhleliingaraa@gmail.com](mailto:munkhiinekhleliingaraa@gmail.com) цахим хаяг;

2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: Дек ХХК оноосон нэр, 000305146 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2080486 регистрийн дугаар, БУ16-850/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Вертикаль ХХК байр, 207 тоот, 99136066 холбоо барих утас, [dec@yahoo.com](mailto:dec@yahoo.com) цахим хаяг;

2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: Титан Манлай ХХК оноосон нэр, 000056543 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5710766 регистрийн дугаар, БУ11-343/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, 2 хороолол, 63, 40 тоот 99101707 холбоо барих утас, [titanmanlailc2013@yahoo.com](mailto:titanmanlailc2013@yahoo.com) цахим хаяг;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: Векэн ХХК оноосон нэр, 000192658 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6036147 регистрийн дугаар, ЗТ12-924/21 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, бага тойруу, Сүхбаатарын талбай 8/1 тоот, сити таур, 1903 тоот, 99990546 холбоо барих утас,

Барилга байгууламжийг ашиглалтанд  
оруулах комисс

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Саруул СӨХ оноосон нэр, 24/09-16 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 9913262 регистрийн дугаар, 99174579 холбоо барих утас;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

□ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул

- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 21 (хорин нэг) автомашины дулаан зогсоолтой, 262 (хоёр зуун жаран хоёр) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилгын байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3. Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

ХЯНАЛТ ШАЛГАЛТ  
ГАЗАР

Барилга байгууламжийг ашиг  
орлуулах комисс

- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 16 давхар 1 блок, 21 (хорин нэг) автомашины дулаан зогсоолтой, 262 (хоёр зуун жаран хоёр) айлын хүчин чадалтай орон сууцны зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сонгинохайрхан дүүргийн 37 дугаар хороо, Мөнхийн эхлэлийн гараа ХХК-ийн захиалгатай, зорьтой 16 давхар 1 блок, 21 (хорин нэг) автомашины дулаан зогсоолтой, 262 (хоёр зуун жаран хоёр) айлын орон сууцны барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

*(Handwritten signature in blue ink)*  
 (Б.Батчимэг)

Нарийн бичгийн дарга: Мөнхийн Эхлэлийн Гараа ХХК-ийн захирал

*(Handwritten signature in blue ink)*  
 (Ц.Галтхүү)

ЛН  
 лалтанд

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭВ.  
 Объектын дугаар: 1015/11/040/08  
 Огноо: 2015.11.04 сар 08 өдөр  
 Бүртгэсэн: *(Signature)*  
 УЛААНБААТАР ХОТ ТТМ №1784

СОНГИНХАЙРХАН ДҮҮРГИЙН 37 ДУГААР ХОРОО, МӨНХИЙН ЭХЛЭЛИЙН ГАРАА ХХК-ИЙН ЗАХИАЛГАТАЙ, ЗООРЬТОЙ 16 ДАВХАР 1 БЛОК, 21 АВТОМАШИНЫ ДУЛААН ЗОГСООЛТОЙ 262 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ БАРИЛГЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 16

Улаанбаатар хот

Сонгинхайрхан дүүргийн 37 дугаар хороо, Мөнхийн Эхлэлийн Гараа ХХК-ийн захиалгатай, зорьтой 16 давхар 1 блок, 21 автомашины дулаан зогсоолтой, 262 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1 дүгээр давхрын 1 өрөөнд 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 09<sup>00</sup> цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 11<sup>00</sup> цагт дуусав.

Хуралд:

- |   |                              |
|---|------------------------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга:   | О.Оджаргал                   |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Мөнхийн эхлэлийн гараа ХХК-ийн захирал  | Ц.Галтхүү                    |
| 3. Хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс Барилга техникийн хяналтын улсын /ахлах/ байцаагч                                     | Ж.Жүгдэрмаа                  |
| 4. Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч   | З.Очирпүрэв                  |
| 5. Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн дарга  | Д.Сүхбат                     |
| 6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер  | Б.Цэрэннадмид<br>Ц.Дагвадорж |
| 7. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК  |                              |
| 8. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер   | Г.Үүрийнгэгээ                |
| 9. Онцгой байдлын ерөнхий газар, барилгын зураг төслийн хяналтын тасаг, дэд хурандаа  | М.Батсайхан<br>Н.Өлзийжаргал |
| 10. Үндэсний Төв Архив, архивч  |                              |
| 11. Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн | О.Ундрах                     |
| 12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан  | Б.Ганбаатар                  |
| 13. Ашиглалт хариуцах байгууллага ХҮТ19   | Ц.Чулуунбаатар               |
| 14. Векэн ХХК-ийн захирал   | М.Өнөрбаяр                   |
| 15. Дек ХХК-ийн захирал   | З.Чимэг                      |

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хүрэлцэн ирсэн -15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

### ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сонгинхайрхан дүүргийн 37 дугаар хороо, Мөнхийн Эхлэлийн Гараа ХХК-ийн захиалгатай, зорьтой 16 давхар 1 блок, 21 автомашины дулаан зогсоолтой, 262 айлын орон сууцны барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

### СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс, Барилгын техникийн хяналтын Улсын /ахлах/ байцаагч **Ж.Жүгдэрмаа:**

- Барилгын угсралтын ажлын тэмдэглэлд зохиогчоос өгсөн үүргийн биелэлт хүлээн авсан инженер зохиогчийн гарын үсгийн биелэлт шалгасан баталгаажуулалт дутууг гүйцээж үзүүлэх,
- зохиогчийн дүгнэлтийг дүрмийн дагуу бичиж хянуулах
- арматурын гарал үүсэл хянуулах.
- Зоорийн давхрын шаланд үүссэн хагарал, хойд талын б блокны орцны лифтний техникийн өрөөний таазанд гарах анкер бэхэлгээний зураг хянуулж дутууг гүйцээж засварлаж фото зургаар баримтжуулах, хянуулах
- Үйлчилгээний 1 дүгээр давхрын гүйцэтгэлийн план зураг хянуулж зохиогчийн дүгнэлтэд хэрхэн тусгасныг шалгуулах ашиглалтын үед орц гарцыг гүйцэтгэлийн зургийн дагуу тайлбар бичиж өгөх.

Хяналт шалгалтын газар, Дэд бүтцийн стандартын хяналтын хэлтэс, Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв:**

- Гадна дулаан, цэвэр бохир усны ил, далд ажлын актууд шалгуулах.
- Дээрх гадна шугам мэдээллийн санд оруулах
- Үзелийн тоног төхөөрөмжийн дуу чимээг багасгах арга хэмжээ авах /айлуудад сонсогдохгүй болгох/
- Гадна хог хаягдал хаях сав байршуулах
- Унданы усны шинжилгээний эрүүл ахуйн дүгнэлт гаргуулах
- Дээвэр дээрхи үнэр гаргагч шугам ил хэсгийг дулаалах,
- Сантехникийн ашиглалтыг тусгай зөвшөөрөлтэй байгууллагад хариуцуулан гэрээ хийх,
- Б блокны агаар сэлгэлтийн механик систем зургийн дагуу угсрах
- Айлуудын босоо шугаманд үзлэгийн ревиз фото зургаар шалгуулах.

Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК, Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн дарга **Д.Сүхбат:**

- Халаах хэрэгсэлд тохируулах халаалт тавих
- УДДТ-ийн химийн ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах
- СӨХ-тэй гэрээ хийж шугам ашиглалтын талаарх мэдээллийг ашиглагч байгууллагад дамжуулах.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Техник хяналтын инженер **Б.Цэрэннадмид:**

- ЕОС-т хаяг бичиглэл засах, АВР-ын самбарын холболт засаж тоолуурыг захиалга авч бүртгүүлэх
- Үйлчилгээний төв, цэцэрлэгийн ХС-ыг ажлын зургийн дагуу угсарч холболтыг хийх
- Цэцэрлэгт нэг тэжээл татагдсан байгаад зургийн автартай зөвшилцөж, нөөц тэжээл

ХЯНА

Барилга бай

С

татах

- Айлуудын ариун цэврийн өрөөний разетгуудад усны хамгаалалт хийх
- Үйлчилгээний төвийн ерөнхий самбарт ерөнхий рубильник тавих /крем авах/
- Үндсэн тэжээлийн дутуу холболтуудыг гүйцээж холболтын протокол шалгуулах
- Гадна цахилгааны кабель шугамыг ИМС-д оруулсан акт шалгуулах
- ХТП-1922 дэд өртөөний өргөтгөлийн ажлаас буусан хуучин тоноглолыг хүлээлцсэн акт шалгуулах
- В1 давхраар кабелийн тавиурыг усны шугам доогуур хийгдсэнд норм дүрэм хангуулах
- Эрчим хүчний тухай хуулийн 30.1.13-дах заалтын дагуу гадна дэд өртөө, шугам сүлжээг хамтарч байгууллагад шилжүүлэх хүсэлт өгөх.
- ЦЭХ-ний төлбөр 2,552,580 төлөх

**Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК, Ц.Дагвадорж:**

- Давхруудын хяналтын камеруудыг суурилуулж ажиллуулах
- Домофон системийг тохироо хийж ажиллуулах
- Холбооны техникийн өрөөг цахилгааны хэсгээс тусад нь төлөвлөж, тоноглолуудыг шилжүүлэх

**Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер Г.Үүрийнгэгээ:**

- Гадна худагт /цэвэр усны/ юүлэгчийг таслах
- Нөөцийн савны хэмжээг зурагт  $V=54 \text{ M}^3$  байхаар тусгагдсан боловч газар дээр нь  $V=50 \text{ M}^3$  багтаамжтай багасгасан учир тайлбар ирүүлэх, мөн ашиглалтын үед савны дотор талын уях боломжгүй таазанд тулгасан учраас нөхцөл боломжоор хангах. /суурийг намасгах/
- Өргөлтийн насос зурагт  $Q=24.5 \text{ M}^3$ ,  $H=67 \text{ M}$  байгаа боловч  $Q=32 \text{ M}^3$ ,  $H=53 \text{ M}$  байгаа учраас тайлбар, тооцоо ирүүлэх
- БУХ-2-оос БУХ-3т холбогдсон хэсгийн фубля хоолой угсрах үеийн фото акт шалгуулах
- Монометр суурилуулах /узельд /

**Онцгой байдлын ерөнхий газар, барилгын зураг төслийн хяналтын тасаг, дэд хурандаа М.Батсайхан:**

- 1-р давхрын үйлчилгээний хэсэгт галын дохиолол мэдээлэгч хийх.
- Даралттай агаар өгөх утаа сорох систем хэвийн болгох /Автоматик хийх/
- Зоорийн давхарын хуваалт, тэмдэг тэмдэглэгээг зураг төслийн дагуу хийх.
- 1-р давхрын угтах хэсгийн дотор заслын материалын гал тэсвэрлэлтийн зэрэг тогтоолгосон дүгнэлт үзүүлэх
- Цахилгааны ерөнхий шиптний өрөөнд бие даасан гал унтраах автомат төхөөрөмж суурилуулах
- 1-р давхрын үйлчилгээний хэсгийн орц, гарц /хаалга/ зураг төслийн хийх

**Үндэсний Төв Архив, архивч Н.Өлзийжаргал:**

- Баримт бичгийн бүрдлийг нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй бүрдүүлэх, бичвэртэй хуудас бүрийг дугаарлаж, дотоод товъёг үйлдэх
- Ажлын зураг болон холбогдох баримтын эх хувийг архивд хүлээлгэн өгөх
- Хуулбар хувийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх

Барилгын хөгжлийн төв, Норм, нормативын хэлтэс, Барилга байгууламжийг байнгын ашиглалтанд хүлээн авах, Норм нормативын сангийн бүрдүүлэлт хариуцсан мэргэжилтэн  
**О.Ундрах:**

- Консалтын доод дулаалга хийсэн акт, фото зураг нөхөж үзүүлэх
- 1-р давхрын чулуун фасадны блок хоорондын температурын заадастай хэсгийг тусад нь салгаж зориулалтын ам дарагч хийх
- Бетоны бат бэхийн лабораторийн дүгнэлтийг блок, давхар бүрээр нь нөхөж үзүүлэх.
- Барилгын тухай хуулийн 5.7.1-д заасны дагуу норм, нормативын төлбөрийг тооцуулж төлөх,
- Дулаан авто зогсоолоос гарах хэсэгт явган зорчигч хамгаалах арга хэмжээг авах

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, хүртээмжийн үнэлгээний ажилтан **Б.Ганбаатар:**

- Нийтийн авто машины зогсоолд ХБХ-н машинд зориулсан зогсоолын өргөн 3м95 см машин зогсох зай 2м45 тэргэнцэртэй хүн бууж суух зай 1м50см эргэх шугам татаж тусгаарлаж өгнө. Зогсоолын урд 1м 80 см шон 30х45 /60х60/ самбар байрлуулна.
- 2 үйлчилгээний заалруу орсон налуу замыг стандартын дагуу болгож засаж 1 талд нэмж нэг бариул хийх
- Үйлчилгээний заалнуудын ариун цэврийн өрөөний /суултуур, угаалтуур/ MNS6065 стандартын шаардлагад нийцсэн туслах тоноглолыг суурилуулна.
- Хойд орцны цахилгаан шатны зарлан мэдээлэх төхөөрөмжийн ажилд оруулах
- Урд талын үйлчилгээний заалруу орсон налуу замыг хийх
- Гадна хаалгыг 86 см багагүй болгож өөрчлөх

Ашиглалт хариуцах байгууллага ХҮТ-19 Инженер **Ц.Чулуунбаатар:**

- Узелийн болон тоног төхөөрөмжийн хаягжуулалтыг бүрэн хийх
- 16-8 давхрын халаалтын коллекторын автомат хий гаргагч тавих

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Зураг төсөл зохиогч байгууллага Векэн ХХК-ийн захирал **М.Өнөрбаяр:**

- Заслын дараах цэвэрлэгээ сайтар хийх
- 1 давхрын Б блок үүдний 1ш хаалга амалгаа хийх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Барилгын ажил гүйцэтгэгч Дек ХХК-ийн захирал **З.Чимэг:**

- Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр барилгыг байнгын ашиглалтанд оруулах хүсэлтэй байна.

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн дарга **О.Оджаргал:**

- БНбаД М-04-16 дагуу зохиогч дүгнэлт гаргах
- БТХ-ийн дагуу барилгад чанарын баталгаа гаргаж албан тоотоор ирүүлэх
- Лифтний байцаагчийн албан шаардлагын биелэлтийг хангуулах
- Дээвэр лүү гарах хэсэгт аюулгүй байдлыг хангасан шат хийх
- Айл өрхүүдийн гадна хаалга мөргөлдөж байгаад зохиогч тайлбар албан тоот ирүүлэх.
- Тагт руу гарах хаалгад чанарын стандарт нийцэж байгаа эсэхэд зохиогч тайлбар ирүүлэх

- А, Б, В, Г, И орон сууцны унталгын өрөөний байгалийн гэрэлтүүлэг алдагдалд нийцэж байгаа эсэхэд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах, хянуулах зохиогч тайлбар ирүүлэх.
- В1 дулаан зогсоолын батлагдсан зураг, хүчин чадлыг хянуулах
- В1 дулаан зогсоол руу орох гарах хэсэгт явган зорчигчийн аюулгүй байдлыг хангуулах.
- Батлагдсан зураг төсөлд тусгагдаагүй гарц, орцыг буулгах.

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

Сонгинхайрхан дүүргийн 37 дугаар хороо, Мөнхийн Эхлэлийн Гараа ХХК-ийн захиалгатай, зoorьтой 16 давхар 1 блок, 21 автомашины дулаан зогсоолтой, 262 айлын орон сууцны барилгыг байнгын ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын

Барилга байгууламжийн ашиглалт,

бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг

түр орон гүйцэтгэгч



Тэмдэглэл хөтөлсөн:

Мөнхийн Эхлэлийн Гараа ХХК-ийн

захирал



(Б.Батчимэг)

(Ц.Галтхүү)

